



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 03 өдөр

Дугаар 11/159

Хархорин сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хот суурины 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл хангах, ажлын явц гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүнг тооцох үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Лхагвасүрэн (Засаг даргын орлогч)
Гишүүдэд: Ц.Үүрийнтуяа (Нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Б.Даваасүрэн (ЭБЦТС ТӨХК-ний Хархорин салбарын дарга)
Э.Базардаарий ("Хархорин ус суваг" ХХК-ний ерөнхий инженер)
Г.Ууганбаяр (Хархорин АЗЗА ТӨХК-ны ерөнхий инженер)
Н.Намхайнямбуу (Онцгой байдлын хэлтэсийн дарга, Дэд хурандаа)
Т.Алтангэрэл (1 дүгээр багийн Засаг дарга)
Р.Сүхбат (2 дугаар багийн Засаг дарга)
Д.Батчулуун (3 дугаар багийн Засаг дарга)
Э.Очир-Эрдэнэ (Архитектор)
Нарийн бичгийн дарга: Г.Лхагвабуд (Хотын захирагчийн албаны ерөнхий менежер)

2. Ажлын хэсэгт даалгах нь:

2.1. Сумын халаалтын зуух, дулааны эх үүсвэрүүд, дулаан усан хангамж, цахилгаан шугам, тоног төхөөрөмжүүдийн найдвартай ажиллагааг хангасан байдалд холбогдох байгууллагуудтай хамтарсан хяналт шалгалтыг зохион байгуулж, засварын ажлыг чанартай гүйцэтгэх, өвлийн түлшний хэрэгцээг төрөл, хэмжээгээр тооцон гаргаж, бэлтгэн нөөцлөх;

2.2.Зам талбайн халтиргаа, гулгааг арилгахад шаардлагатай багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжийг бэлтгэж, иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах;


2.3.Энэ онд хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын ажлуудыг эрчимжүүлж, төлөвлөсөн хугацаанд нь чанартай хийж, гүйцэтгэлд нь хяналт тавьж мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх;

2.4.Сургууль, цэцэрлэг, дотуур байрны барилгыг өвлийн улиралд тасралтгүй хэвийн үйл ажиллагаа явуулах стандарт хангагдаж байгаа эсэхэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх;

2.5.Өрхийн эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлгийн зүгээс хүйтний улиралд иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хэвийн хүргэх боломжийг хангаж, шаардлагатай эм бэлдмэл, бааж хэрэгслийн нөөцийг бий болгосон, эмнэлгийн түргэн тусламжийн машины бэлэн байдлыг хангасан эсэхэд хяналт шалгалт хийх;

3.Төв, суурины 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын нэгдсэн удирдагаар ханган зохион байгуулж, тайланг Засаг даргын дэргэдэх зөвлөлд танилцуулааг ажлын хэсэг (Б.Лхагвасүрэн)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Г.ОДГЭРЭЛ



401100317